



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/170

Бат-Өлзий сум

Орон нутгийн төсөвт Мал тоо толгойн албан татвар, ойн орлого төвлөрүүлэх ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.19, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сум орон нутгийн төсөвт Малын тоо толгойн албан татвар, ойн орлого төвлөрүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)
Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)
Н.Батсайхан (Татварын улсын байцаагч)
Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)
Ө.Гөлгөө (Байгаль хамгаалагч)
Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын нярав)

2.Орон нутгийн төсөвт Малын тоо толгойн албан татвар, ойн орлого төвлөрүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН